



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/243

Булган сум

“Цахим Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх  
ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд батлагдсан “Цахим Булган” хөтөлбөрийн 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: О.Далайцэрэн (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)

Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Шижирбаатар (Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Булган (Булган аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга)

Г.Насантогтох (Теле камерын хяналтын дэд төвийн дарга)

Б.Нямсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн)


Д.Өлзийчимэг (Булган аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Хонгорзул (Аймгийн Засаг даргын тамгын газрын

6326010329

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
Өргөдөл гомдол, мэдээллийн ил тод байдал,  
цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

2.Дэд хөтөлбөрийн төлөвлөлтийг хэмжигдэхүйц, хүрч болохуйцаар төлөвлөж, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын үүргийг нэг бүрчлэн тодорхойлж, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Насанжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР